

БАТЛАВ. ШУТИС-ийн ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ГАЗРЫН ДАРГА



Б.ТҮМЭНДЭЛГЭР

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

“УЛААНБААТАР МАРАФОН-2026” ОРОЛЦОХ НЭГДСЭН УДИРДАМЖ

2026.05.06

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү удирдамжийн зорилго нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буй “Улаанбаатар марафон - 2026” олон улсын гүйлтэд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (ШУТИС) багш, ажилтан нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцох үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Марафонд оролцсоноор ШУТИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний салбараас гадна **эрүүл мэнд, спортыг дэмжигч байгууллага** гэсэн эерэг төрхийг олон нийтэд сурталчлах, сургуулийн брэнд имижийг бэхжүүлэх ач холбогдолтой.
- 1.3. ШУТИС нь “Улаанбаатар марафонд” жил бүр уламжлал болгон оролцоно.

Хоёр. Зорилго, зорилт

- 2.1. Их сургуулийн хамт олны нэгдмэл байдал, **БИД НЭГ ШУТИС** соёлыг бэхжүүлэх.
- 2.2. Багш, ажилтан, оюутан, төгсөгчдийн дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлж, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх.
- 2.3. Спортын зөв дадал, соёлоор дамжуулан ШУТИС-ийн нэр хүндийг дотоод болон гадаадад сурталчлан таниулах.

Гурав. Хамрах хүрээ

- 3.1. Тэмцээнд ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгчид сайн дурын үндсэн дээр оролцоно.
- 3.2. Бүрэлдэхүүн сургууль бүр **10-аас дээш хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулалттай** оролцох бөгөөд оролцогчид марафон зохион байгуулах ажлын хэсгээс тогтоосон насны ангиллын дагуу (18-55 нас) оролцоно.

Дөрөв. Хугацаа, байршил

- 4.1. **Марафон болох өдөр:** 2026 оны **05 дугаар сарын 23-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд болно.**
- 4.2. **Цуглах хугацаа:** Марафоны өдөр ШУТИС-ийн оролцогчид их сургуулийн төв байрны задгай талбайд **07:30 цагт** цуглаж, нэгдсэн бие халаалт хийж,

мэргэжлийн багш нараас гүйлтийн зөвлөгөө авсны дараа гарааны цэг рүү хөдөлнө.

- 4.3. Гараа, бариаг албан ёсны марафоны зохион байгуулагчийн мэдээллээр тодорхойлно.
- 4.4. Оролцогчид сургуулийн өнгө төрхийг илэрхийлсэн **нэгдсэн өмсгөл, брэнд таних тэмдэгтэй** (Футболк гэх мэт) байна.

Тав. Төрөл, зай

- 5.1. ШУТИС-ийн нэгдсэн баг **“Улаанбаатар марафон-2026” Эрүүл мэндийн гүйлтийн 5 км-ийн төрөлд** оролцоно
- 5.2. **Техникийн зөвлөгөөн:** 2026 оны **05** дугаар сарын **12-ны 12:30** цагт ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн өрөөнд **(1-203)** болно. Бүрэлдэхүүн сургуулийн төлөөлөл оролцогчдын нэрс, гүйлтийн зайн мэдээллийг бүрдүүлж ирнэ.

Зургаа. Аюулгүй байдал, зохион байгуулалт

- 6.1. Оролцогчид албан ёсны маршрутын дагуу гүйж, зохион байгуулагчдын заавар, аюулгүй байдлын шаардлагыг чанд мөрдөнө.
- 6.2. Оролцогчид марафоны өмнө эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх ба зүрх судас, даралтын асуудалтай тохиолдолд гүйлтэд оролцохгүй байхыг анхааруулна.
- 6.3. Зохион байгуулагчдын зүгээс бүх оролцогчдод эрүүл мэндийн зөвлөгөө, аюулгүй байдлын зааврыг “Улаанбаатар марафон - 2026” болох өдрөөс 7-14 хоногийн өмнөөс эхлэн тэмцээнд бэлтгэх зөвлөмж хүргэнэ.

Долоо. Шүүгч, зохион байгуулалт

- 7.1. ШУТИС-ийн Биеийн тамир, спортын тэнхим марафонд оролцох үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, барианд орсон дараалал, хугацааг дотооддоо бүртгэнэ.
- 7.2. Биеийн тамир, спортын тэнхимийн багш нар барианд орсон дараалал, хугацааг бүртгэнэ.

Найм. Шагнал урамшуулал

- 8.1. Сургуулийн нэр хүндийг гаргаж, амжилттай оролцсон **эхний 30 хүнд ШУТИС-ийн нэрэмжит дурсгалын медаль** гардуулна.

Зохион байгуулагч:

Захиргааны удирдлагын газар
ХШУС, Биеийн тамир, спортын тэнхим

Холбоо барих:

Утас: 89557744, 88992020

И-мэйл: sh.dorjsuren@must.edu.mn, ganzorig@must.edu.mn

Зөвлөмж:

“Улаанбаатар марафон - 2026” олон улсын гүйлтэд оролцох ШУТИС-ийн багш, ажилтан, оюутнууд нь өмнөх жилүүдийн марафонд ашигласан ШУТИС-ийн нэгдсэн өмсгөл, футболк зэргийг өмсөн оролцож болно.

Өмнөх жилийн нэгдсэн өмсгөлгүй оролцогчид энэхүү удирдамжид хавсаргасан загвар, өнгө дизайны дагуу бүрэлдэхүүн сургууль болон нэгжээс өөрийн зардлаар хийлгэж болно.

Оролцогчид нь ШУТИС-ийн нэгдсэн өнгө төрх, байгууллагын соёлыг илэрхийлэх зорилгоор ижил загвар, өнгө бүхий өмсгөлтэй оролцох бөгөөд хоорондоо огт ялгаатай, жигд бус хувцастай оролцохгүй байхыг анхаарна.

Үндсэн өнгө:

Их бие ШУТИС-ийн үндсэн хөх, ханцуй үндсэн шар

Нэмэлт өнгө: Бүрэлдэхүүн сургууль тус бүрийн өнгөөр хийгдэнэ.

Их биенд – хормой хэсгийн уусгалт болон оруулга

Мөр, ханцуйнд – мөрний кант, ханцуйны эмжээр

Ар нуруунд – ШУТИС, Бүрэлдэхүүн сургуулийн нэр

Өмсгөл загвар

БАС



ГУУС



ГХС



ДАТС



МИТС



МС



МХТС



НХС



ХХҮДС



ЭХС



ШУТИС



ХШУС



“Улаанбаатар марафон - 2026” олон улсын гүйлтэд ашиглах ШУТИС-ийн стикерийн цуглуулга



